ШССМХ-ийн захирлын 2023 оны 05 сарын
18-ны өдрийн А/11 тоот тушаалын хавсралт

# ЭШЛЭЛ ХИЙХ, ЭХ СУРВАЛЖИЙГ ЗААХ, НОМ ЗҮЙН БИЧИЛТ ХИЙХ СТАНДАРТ

## 1. Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн хийж гүйцэтгэж буй эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудад эшлэл хийх, эх сурвалжийг заах, ном зүйн бичилт хийх шаардлагыг тогтооно.

## 2. Нэр томьёо

**Эшлэл:** Бусад бүтээлд дурдагдсан мэдээлэл болон санааг шууд болон шууд бусаар эш татан хэрэглэхийг ойлгоно.

**Бичвэрт заагдсан эх сурвалж:** Үндсэн бичвэрт эш татсан тухайн хэсэгтээ эшлэлийн эх сурвалжийг хаалтад дурдаж оруулахыг ойлгоно.

**Зүүлт тайлбар (footnote)-т заагдсан эх сурвалж:** Шууд болон шууд бусаар эшилсэн эх сурвалжаа зүүлт тайлбар хэсэгт дурдаж оруулахыг ойлгоно.

**Ном зүй:** Эшлэлд дурдагдсан болон тухайн судалгааны ажилд ашигласан ном, сурах бичиг, гарын авлага, эмхэтгэл, судалгааны тайлан, орчуулгын бүтээл, эрдмийн зэрэг горилсон бүтээл, өгүүлэл, илтгэл, нийтлэл, эрх зүйн баримт бичиг, цахим орчин дахь мэдээлэл зэрэг бүх төрлийн эх сурвалжуудыг ойлгоно.

## 3. Ерөнхий шаардлага

3.1. Шууд эшлэл: Эшлэл нь 40-өөс доошгүй үгтэй тохиолдолд шууд эшлэл авч болох бөгөөд эшилж авсан хэсэг, санаа, нэр томьёог “ ” хашилтад хийж өөрийн бичвэрээс зааглана.

3.2. Шууд эшлэл нь 40-өөс дээш үгтэй бол хашилтад хийхгүй бөгөөд эшилсэн хэсгийг бүхэлд нь зүүн гар талаас догол мөр үүсгэн тусгайлан бичнэ.

3.3. Шууд болон шууд бус эшлэл хийх тохиолдолд эх сурвалжийг тухайн эшлэлийн ард хаалт нээж дурдах эсхүл зүүлт тайлбар /footnote/ хэсэгт дурдах төдийгүй “ном зүй” хэсгийн жагсаалтад оруулна.

3.4. Мөн зүүлт тайлбар /footnote/-ыг үгийн тайлбар, нэмэлт тайлбар, залруулга, нэмж судлах материалуудын талаарх мэдээлэл өгөх тохиолдолд хэрэглэж болно.

3.5. Шууд болон шууд бусаар эшилж байгаа хэсгээс гол санааг тодруулах, өөр форматаар өөрчилж бичих тохиолдолд “Судлаачийн зүгээс зарим хэсгийг тодруулсан болно.” гэж зүүлт тайлбар хэсэгт бичнэ.

3.6. Үндсэн эшлэл нь бүтэн биш бол дутуу хэсэгт нь (...) гэж 3 цэг бичнэ.

3.7. Он бичих тохиолдолд (2023) гэх мэт “он” гэдэг үггүй бичнэ.

3.8. Сар, өдөр бичих тохиолдолд 05, 07 гэх мэт 0-тай бичнэ.

3.9. Хуудас бичих тохиолдолд “дахь тал, дэх тал, дох тал” гэж бичнэ.

## 4. Бичвэр дотор эх сурвалжийг заах

Бичвэр дотор эх сурвалжийг дурдахдаа Хавсралт 1-д заасны дагуу бичих бөгөөд зохиогч болон хэвлэсэн он, хуудасны дугаарыг заана.

## 5. Зүүлт тайлбарт эх сурвалжийг заах

Зүүлт тайлбарт эх сурвалжийг заахдаа Хавсралт 2-ыг баримтална. Гадаад хэлээс эшлэл аван зүүлт тайлбар хэсэгт эх сурвалжийг дурдах тохиолдолд Хавсралт 4-ыг мөрдөнө.

## 6. Ном зүйд эх сурвалжийг заах

6.1. Ном зүйд эх сурвалжийг бичихдээ Хавсралт 3-ыг баримтална.

6.2. "НОМ ЗҮЙ"-г судалгааны ажлын төгсгөл хэсэгт, тухайн хэлний цагаан толгойн үсгийн дараалаар, дугаарлаж бичнэ.

6.3. Ном зүйг бичихдээ "Монгол эх сурвалж", "Гадаад эх сурвалж", "Эрх зүйн эх сурвалж," "Цахим хуудас" –д ангилж бичнэ. "Эрх зүйн эх сурвалж" хэсэгт дотоодын болон гадаад улсын хууль тогтоомж, шүүхийн шийдвэрийг бичнэ.

"Цахим хуудас" хэсэгт мэдээллийг олж авсан цахим хуудасны хаягийг бичих бөгөөд дэлгэрэнгүй холбоос болон сүүлд үзсэн он, сар, өдөр зэргийг бичихгүй. Харин тухайн хуудасны нэрийг бичнэ. Жишээ нь: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, www.legalinfo.mn гэх мэт.

6.4. Ном зүйн жагсаалт бичихдээ цагаан толгойн үсгийн дараалалыг баримтлах бөгөөд дараах зүйлийг анхаарвал зохино.

6.4.1. Нэг зохиогчийн хэд хэдэн бүтээлийг ном зүйд оны дараалын дагуу бичнэ.

6.4.2. Олон зохиогчтой эх сурвалжийн зохиогч тус бүрийг дурдах ба тухайн бүтээлд хэвлэсэн хамгийн эхний зохиогчийн нэрийг баримтлан дараалуулна.

6.4.3. Зохиогчгүй, эмхэтгэгч, редактортай бүтээлийг ном зүйд оруулахдаа редакторын нэрийг дээрх зарчмаар дараалуулна.

6.4.4. Зохиогч, эмхэтгэгчгүй бол эрхлэн гаргасан байгууллагын нэрийг бүтнээр нь оруулах ба нэрийн эхний үгийг цагаан толгойн үсгийн дараалаар дараалуулна.

6.4.5. Хичээл, хурлын тэмдэглэл, гар бичмэл, радио, телевизийн нэвтрүүлэг, ярилцлага зэрэгт эшлэлийн эзний нэрийг, эшлэлийн эзэн тодорхойгүй тохиолдолд хурал, нэвтрүүлэг зэрэг үйл ажиллагааны нэр хаягийн эхний үгээр дараалуулна.

## ХАВСРАЛТ 1. ЭХ БИЧВЭР ДОТОР ЭХ СУРВАЛЖИЙГ ДУРДАХ ЖИШЭЭ

А. **Нэг зохиогчийн бүтээлийг** эш татах тохиолдолд дараах байдлаар бичнэ.

1. Зохиогчийн нэрийг өгүүлбэрт дурдаагүй тохиолдолд хаалтад зохиогчийн нэр, он, хуудасны дугаарыг бичнэ.

*Жишээ:*

Манайд бол “төр”, “улс” гэсэн хоёр үг хууль зүйн нэр томьёоны хувьд нэгэн адил утга, багтаамжтай гэж болно (Чимид, 1989, 1 дэх тал).

2. Зохиогчийн нэрийг өгүүлбэрт оруулсан бол хаалтад дахин зохиогчийн нэрийг нь дурдалгүйгээр зөвхөн он, хуудасны дугаарыг бичнэ.

*Жишээ:*

Б.Чимид (1989, 1 дэх тал) “төр”, “улс” гэсэн хоёр үг хууль зүйн ...

Б. **Олон зохиогчтой бүтээлээс** эш татах тохиолдолд дараах байдлаар бичнэ.

1. 2 зохиогчтой бүтээлээс эшилсэн бол эшлэх тохиолдол бүрд 2 зохиогчийн нэрийг хоёуланг дурдана.

*Жишээ:*

Судлаачид (Чимид, Совд, 1993, 56 дахь тал) энэ тухайд ...

2. 2-5 зохиогчтой бүтээлээс эш татвал хамгийн эхний эшлэлийн тайлбарт бүх зохиогчийн нэрийг бичээд дараа нь тэр бүтээлээс дахин эш татсан тохиолдолд зөвхөн эхний зохиогчийн нэрийг дурдаад бусад зохигчийн нэрийг бичилгүй “бусад” гэж товчилно.

*Жишээ:*

*Эхний эшлэлд:* (Чимид, Совд, Нарангэрэл, 1996, 32 дахь тал)

*Дараагийн эшлэлүүд:* (Совд ба бусад, 1996, 32 дахь тал)

В. **Байгууллагаас эрхлэн гаргасан номоос** эшлэх тохиолдолд дараах байдлаар бичнэ.

*Жишээ:*

(Нээлттэй Нийгэм Форум, 2004, 26 дахь тал)

Г. **Сэтгүүлийн өгүүллийг** эшлэхэд дараах дараалаар бичнэ.

*Жишээ:*

(Сүнжид, 2022,10 дахь тал)

Д. **Зохиогч нь тодорхойгүй үед** тухайн өгүүллийн гарчиг эсхүл бүлгийн нэр, веб хуудсыг **(“”)** хашилтад бичнэ.

*Жишээ:*

(“Эвслийн засгийн газруудын эргэж задарсан түүх,” 2015)

(“politics.news.mn,” 2015)

Е. **Зохиогч нь тодорхойгүй бөгөөд тогтмол хэвлэл**, ном, товхимол болон тайлангийн нэрийг налуу (*Italic*) хэлбэрт оруулан бичнэ.

*Жишээ:*

(*Монголын мэдээ*, 2011)

## ХАВСРАЛТ 2. ЗҮҮЛТ ТАЙЛБАР ХЭСЭГТ ЭХ СУРВАЛЖИЙГ ДУРДАХ ЖИШЭЭ

### А. НОМ

| | |
|---|---|
| **Нэг зохиогчтой ном** | *Загвар:*<br>Зохиогчийн овгийн эхний үсэг.нэр, *Бүтээлийн нэр*, Хэвлэсэн он, хуудасны дугаар. |
| | *Жишээ:*<br>Н.Лүндэндорж, *Шилжилтийн үе: улс төр, эрх зүйн асуудал*, 2010, 19 дэх тал. |
| **Хоёр зохиогчтой ном** | *Загвар:*<br>Зохиогчийн овгийн эхний үсэг.нэр, Зохиогчийн овгийн эхний үсэг.нэр, *Бүтээлийн нэр*, Хэвлэсэн он, хуудасны дугаар. |
| | *Жишээ:*<br>Б.Баярдаваа, Д.Гансүлд, *Макроэкономикс* (2 дахь хэвлэл), 2006, 6 дахь тал. |
| **Гурваас таван зохиогчтой ном** | *Загвар:*<br>Зохиогчийн овгийн эхний үсэг.нэр, хоёр дахь, гурав дахь, дөрөв дахь зохиогчийн нэр, *Бүтээлийн нэр*, хэвлэсэн он, хуудасны дугаар. |
| | *Жишээ:*<br>Б.Дэлгэрмаа, Д.Оюун, Ж.Хулан, *Бизнесийн эрх зүй* (2 дахь хэвлэл), 2010, 80-83 дахь тал. |
| **Зохиогч тодорхойгүй, нэг редактортай ном** | *Загвар:*<br>Редакторын овгийн эхний үсэг.нэр (Ред), Бүтээлийн нэр, Хэвлэсэн он, хуудасны дугаар. |
| | *Жишээ:*<br>Ц.Содов (Ред), *Боловсрол судлалын үндэс*, 2009, 10 дахь тал. |
| **Байгууллагаас эрхлэн гаргасан ном** | *Загвар:*<br>Эрхлэн гаргасан байгууллагын нэр, Бүтээлийн нэр, хэвлэсэн он, хуудасны дугаар. |
| | *Жишээ:*<br>Нээлттэй нийгэм форум, *Төрийн бус байгууллага ба татвар*, 2004, 5 дахь тал. |

### Б. ӨГҮҮЛЭЛ

| | |
|---|---|
| **Нэг зохиогчтой өгүүлэл** | *Загвар:*<br>Зохиогчийн овгийн эхний үсэг.нэр, “Өгүүллийн нэр,” *Сэтгүүлийн нэр, Сэтгүүл гаралтын дугаар*, (тухайн оны дугаар), Он, Хуудасны дугаар. |
| | *Жишээ:*<br>О.Мөнхсайхан, “Монгол Улс дахь засгийн газрыг эмхлэн байгуулах ажиллагааг боловсронгуй болгох нь,” *Хууль дээдлэх ёс 51* (1), 2015, 55-66 дахь тал. |
| **Хоёр зохиогчтой өгүүлэл** | *Загвар:*<br>Зохиогчийн овгийн эхний үсэг.нэр, Хоёр дахь зохиогчийн нэр, “Өгүүллийн нэр,” *Сэтгүүлийн нэр, Сэтгүүл гаралтын дугаар*, (тухайн оны дугаар), Он, Хуудасны дугаар. |
| | *Жишээ:*<br>Б.Амарбаясгалан, Т.Мөнх-эрдэнэ, “*Шүүхийн ил тод байдал: шүүгчийн тусгай санал ба саналын тооны харьцааг нийтлэх шаардлага,*” Монголын төр, эрх зүй 104 (2), 2023, 6 дахь тал. |
| **Цахим өгүүлэл** | *Загвар:*<br>Зохиогчийн овгийн эхний үсэг.нэр, “Өгүүллийн нэр,” *цахим хуудасны хаяг*, Өгүүлэл бичигдсэн он, хуудасны дугаар. |
| | *Жишээ:* |

| | |
|---|---|
| | Ц.Цогт, "Монгол Улсын захиргааны хэргийн шүүхийн эрх зүйн орчин, дүн шинжилгээ," *legaldata.mn*, 2023, 11 дэх тал. |

**В. БУСАД**

| | |
|---|---|
| **Докторын диссертац** | *Загвар:*<br>Зохиогчийн овгийн эхний үсэг.нэр, *Диссертацийн нэр*, он, хуудасны дугаар. |
| | *Жишээ:*<br>П.Гантөмөр, *Эдийн засгийн өсөлтөд нөлөөлөгч зарим хүчин зүйлсийн шинжилгээ*, Эдийн засгийн ухааны докторын диссертац, 2015, 150 дахь тал. |
| **Илтгэл** | *Загвар:*<br>Илтгэгчийн овгийн эхний үсэг.нэр, "*Илтгэлийн нэр*," хурлын нэр, (хурал болсон он, сар өдөр), Хурал болсон хот, улс. |
| | *Жишээ:*<br>Ц.Сарантуяа, "*Үндсэн хуулийн маргаан шийдвэрлэх ажиллагааны зарим асуудал*," Үндсэн хуулийн болон захиргааны эрх зүйн үндсэн асуудал: хямралын үеийн тулгамдсан асуудал олон улсын эрдэм шинжилгээний 3 хурал (2021.11.20), Улаанбаатар, Монгол. |
| **Хурлын тэмдэглэл** | *Загвар:*<br>Хурал зохион байгуулсан газар, хурал болсон өдөр, эх сурвалж цахим хуудас, (Сүүлд үзсэн: он.сар.өдөр). |
| | *Жишээ:*<br>УИХ-ын ТББХ, 2017.10.26-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, https://www.parliament.mn/nn/1102/ , (Сүүлд үзсэн: 2023.05.03). |
| **Цахим хуудасны мэдээ, пост (зохиогч нь тодорхойгүй бол)** | *Загвар:*<br>"Мэдээний гарчиг," Мэдээ гарсан он, эх сурвалж цахим хуудасны холбоос, (Сүүлд үзсэн: он.сар.өдөр). |
| | *Жишээ:*<br>"Эвслийн засгийн газруудын эргэж задарсан түүх," 2020, http://politics.news.mn/content/127486.shtml, (Сүүлд үзсэн: 2015.03.21). |
| **Сонин** | *Загвар:*<br>Зохиогчийн овгийн эхний үсэг.нэр, "*Өгүүллийн нэр*," Сонины нэр, дугаар, (хэвлэсэн он, сар,өдөр), хуудасны дугаар. |
| | *Жишээ:*<br>Х.Батсайхан, "*Алтны ханш галзуурсан нь цөвүүн цагийн дохио юу*," Монголын мэдээ, №090(3175), (2011.05.06), 10 дахь тал. |
| **Хуулийн заалт** | *Загвар:*<br>Хуулийн нэр (батлагдсан он) зүйл заалтын дугаар "..." |
| | *Жишээ:*<br>*Эхний удаад эшлэх тохиолдолд:*<br>Захиргааны ерөнхий хууль (2015)-ийн 35 дугаар зүйлийн 35.1 "..."<br>*Хоёр дахь удаа эшлэх тохиолдолд:*<br>ЗЕХ-ийн ... |
| **Шүүхийн шийдвэр** | *Загвар:*<br>Шүүхийн нэр, он сар өдөр, шийдвэрийн дугаарыг өгүүлбэр хэлбэрээр бичнэ, шийдвэрийг үзэх холбоос. |
| | *Жишээ:*<br>*Эхний удаад Улсын дээд шүүхийн тогтоолыг эшлэх тохиолдолд:*<br>Улсын дээд шүүхийн 2023 оны 04 сарын 18 өдрийн 001/ХТ2023/00066 тогтоол, https://shuukh.mn/single_case/10200?daterange=2023/01.<br>*Хоёр дахь удаа Улсын дээд шүүхийн тогтоолыг эшлэх тохиолдолд:*<br>УДШ-ийн 2023 оны 04 сарын 20 өдрийн ... |

## ХАВСРАЛТ 3. НОМ ЗҮЙ БИЧИХ ЖИШЭЭ

### А. Монгол эх сурвалж:


1. Б.Амарсанаа, *Харьцуулсан эрх зүй судлал.* 2 дахь хэвлэл, 2014.
2. Венецийн комисс, *Монгол Улсын улс төрийн намын тухай хуулийн төсөл, санал, дүгнэлт*, 2022.
3. Ц.Цогт, “Монгол Улсын захиргааны хэргийн шүүхийн эрх зүйн орчин, дүн шинжилгээ,” *legaldata.mn*, 2023.
4. Шилэн нам авлигын эсрэг түншлэл, *Улс төрийн санхүүжилтийн ил тод байдал, авлигын эрсдэлийн үнэлгээний тайлан*, 2018.


### Б. Гадаад эх сурвалж:


1. Robert E.Much, *Campaigns, Congress, and Courts- The Making of Federal Campaign Finance Law*, (Praeger, 1988).
2. IDEA. Helena Catt , Andrew Ellis, Michael Maley, Alan Wall, Peter Wolf , *Electoral management design*, Revised edition. (Bulls Graphics,2014).
3. 近藤昌昭ほか『仲裁法コンメンタール』（商事法務、2003）。


### В. Эрх зүйн эх сурвалж:


1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль (2020).
2. Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль (2019).
3. Улс төрийн намын тухай хууль (2005)
4. Улсын дээд шүүхийн 2023 оны 04 сарын 18 өдрийн 001/ХТ2023/00066 тогтоол.
5. Япон улсын Шүүгчийн статусын тухай хууль (1947).


### Г. Цахим эх сурвалж:


1. Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: https://legalinfo.mn/mn
2. Улсын Их Хурлын Тамгын газрын цахим хуудас: https://www.parliament.mn/nn/17671/
3. Япон улсын төрийн албаны зөвлөлийн цахим хуудас: https://www.jinji.go.jp


МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА, МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН

**ХАВСРАЛТ 4. ГАДААД ЭХ СУРВАЛЖААС ЭШЛЭЛ ХИЙХ ЖИШЭЭ**

## 1. АНГЛИ ХЭЛ ДЭЭРХ ЭШЛЭЛ[1]

| | |
|---|---|
| **Ном** | *Загвар:*<br>Зохиогчийн нэр, *Бүтээлийн нэр* (Хэвлэлийн газар, он), хуудасны дугаар. |
| | *Жишээ:*<br>*Эхний удаад эшлэх тохиолдолд:*<br>[5] Nihal Jayawickrama, *The Judicial Application of Human Rights Law: National, Regional and international Jurisprudence*, 1st ed. (Cambridge University Press, 2003), 283-284.<br>*Хоёр дахь удаагаа эшлэх тохиолдолд*:<br>Ibid 478.<br>Jayawickrama, *supra* note 5. 100. |
| **Өгүүлэл** | *Загвар:*<br>Зохиогчийн нэр, “Өгүүллийн нэр,” *Сэтгүүлийн нэр*, дугаар (хэвлэгдсэн он), хуудасны дугаар. |
| | *Жишээ:*<br>John D.Huber and Cecilia Martinez-Gallardo, “Replacing Cabinet Ministers: patterns of Ministerial Stability in Parliamentary Democracies,” *American Political Science Review* 102, no2 (May 2008), 169. |
| **Хуулийн заалт** | *Загвар:*<br>Хуулийн нэр (батлагдсан он), зүйл заалтын дугаар. |
| | *Жишээ:*<br>Constitution of Moldova (1994), art. 9(2).<br>Administrative Procedure Act §76 “..........” |
| **Шүүхийн шийдвэр** | *Загвар:*<br>Хэргийн нэр, шүүхийн шийдвэрийн эмхэтгэлийн дугаар, шийдвэрийн товчлол, эхлэх хуудас- тухайн хуудас (харьяалах шүүхийн товчлол, шийдвэрийн он). |
| | *Жишээ:*<br>United States v. MacDonald, 531 F.2d 196, 199-200 (4th Cir. 1976).<br>Meritor Sav. Bank v. Vinson, 477 U.S. 57, 60 (1986) . |
| **Хурал** | *Загвар:*<br>Илтгэгчийн нэр, илтгэлийн нэр (Хурлын нэр, зохион байгуулагдсан газар, он сар өдөр), хуудасны дугаар, үзэх холбоос. |
| | *Жишээ:*<br>Csaba nikolenyi, “The Impact of Government Formation rules in Four Post-Communist Democracies” (World Congress of the International political Science Association, Fukuoka, Japan, July 10, 2006),14, http://paperroom.ipsa.org/papers/paper_5077.pdf. |
| **Мэдээ** | *Загвар:*<br>“Мэдээний гарчиг,” Эх сурвалж, үзсэн он сар өдөр, холбоос. |
| | *Жишээ:*<br>“Australian NSW Leader Resigns over Wine Gift,” BBC News Asia, April 16, 2014, http://www.bbc.com/news/world-asia-27045603. |

[1] Токиогийн их сургуулийн Хууль зүйн сургуулийн бэлтгэсэн эшлэл хийх аргачлал буюу 東京大学法科大学院ローレビュー第 12 期編集委員会「東京大学法科大学院ローレビューにおける文献の引用方法」（2017 年 ）-ийг ашигласан болно.

Мөн О.Мөнхсайхан “Ишлэл хийх нь (Чикаго хэв маяг),” Хууль зүйн судалгаа, анализ, бичлэг хичээл, 2015, 1-2 дахь талыг ашигласан болно.

| | |
|---|---|
| **Олон улсын гэрээ** | *Жишээ:*<br>Article 28, Convention on the Rights of the Child (adopted 20 November 1989, entered into force 2 September 2000) UN Doc A/44/49 (1989) (CRC), https://www.ohchr.org/en/instruments-mechanisms/instruments/convention-rights-child |
| **The International Court of Justice-ийн шийдвэрийг эшлэх** | *Жишээ:*<br>Military and Paramilitary Activities (Nicar. v. U.S.), 1986 I.C.J.14, 181 (June 27). |
| **European Union Courts –ийн шийдвэрийг эшлэх** | *Жишээ:*<br>Case T-198/98, Micro Leader Bus. v. Comm'n, 1999 E.C.R. II-3989. |
| **European Court of Human Rights-ийн шийдвэрийг эшлэх** | *Жишээ:*<br>Papon v. France (No.2), 2001-XII Eur. Ct. H.R. 235. |

## 2. ОРОС ХЭЛ ДЭЭРХ ЭШЛЭЛ[2]

| | |
|---|---|
| **Ном** | *Загвар:*<br>Зохиогчийн нэр. Бүтээлийн нэр. - Хэвлэсэн газрын товчлол.:хэвлэлийн газар, он.- хуудасны дугаар. |
| | *Жишээ:*<br>Антокольская М.В. Семейное право: Учебник. – М.: Юрист, 2017. – 336 с. |
| **Өгүүлэл** | *Загвар:*<br>Зохиогчийн нэр. Бүтээлийн нэр // сэтгүүлийн нэр. – хэвлэсэн газрын товчлол.:хэвлэлийн газар, он.- хуудасны дугаар. |
| | *Жишээ:*<br>Гараймович Д.А. Оценочные понятия в современном гражданском праве// Цивилистические записки: Межвузовский сборник научных трудов. – М.:Статут, 2001. – С. 144-153. |
| **Хуулийн заалт** | *Загвар:*<br>Хуулийн нэр : [батлагдсан он] // эх сурвалж. - ...(Сүүлд үзсэн: он.сар.өдөр). |
| | *Жишээ:*<br>1. Конституция Российской Федерации: [принята всенародным голосованием 12 декабря 1993 г. с изменениями, одобренными в ходе общероссийского голосования 01 июля 2020 г.] // Официальный интернет–портал правовой информации. – URL: http://www.pravo.gov.ru (дата обращения: 18.04.2023).<br>2. Гражданский кодекс Российской Федерации (часть 1) от 30 ноября 1994г. № 51-ФЗ (в актуальной редакции) //Российская газета. 1994. 08 декабря; Гражданский кодекс Российской Федерации (часть 2) от 26 января 1996г. № 14-ФЗ (в |

[2] Орос хэл дээр эшлэл авах тухай 2019 онд Ростовын Улсын Эдийн Засгийн Их Сургуулийн иргэний эрх зүйн тэнхимээс гаргасан “Эх сурвалжуудыг эшлэх жишээ” –г ашигласан болно. Дэлгэрүүлэн үзэх холбоос: Образец_оформления_списка_использованных_источников,_сносок,_рисунков.pdf

| | |
|---|---|
| | актуальной редакции) // Собрание законодательства РФ. 1996. № 5. Ст. 410. |
| **Шүүхийн шийдвэр** | *Загвар:*<br>Шүүхийн нэр, шийдвэрийн он сар өдөр, дугаар // эх сурвалж: ... |
| | *Жишээ:*<br>Решение Верховного Суда РФ от 8 апреля 2015г. № ВКГПИ15-9 //Неофиц. ист.: Справочно-правовая система «Консультант Плюс». |

## 3. ГЕРМАН ХЭЛ ДЭЭРХ ЭШЛЭЛ[3]

| | |
|---|---|
| **Ном** | *Загвар:*<br>Зохиогчийн овог, нэр: Бүтээлийн нэр, Хэвлэсэн үйлдвэр, Хот, Улс, Хэвлэсэн он, Хуудасны дугаар. |
| | *Жишээ:*<br>*Эхний удаад эшлэх тохиолдолд:*<br>Schmidt, Bernd: Richtig zitieren: eine Anleitung für Studierende, 2. Aufl., Berlin, Deutschland: Springer, 2020, S. 117.<br><br>*Хоёр дахь удаад эшлэх тохиолдолд:*<br>Schmidt, 2020, S. 117. |
| **Өгүүлэл** | *Загвар:*<br>Зохиогчийн овог, нэр: Өгүүллийн нэр, Сэтгүүлийн нэр, Сэтгүүлийн дугаар, Хэвлэсэн он, (DOI) Digital Object Identifier, Сэтгүүлийн хуудас. |
| | *Жишээ:*<br>Elsen, Hilke: Neologismen in der Jugendsprache, in: Muttersprache: Vierteljahrsschrift für deutsche Sprache, Bd. 112, Nr. 2, 2002, doi:10.5282/ubm/epub.14557, S. 140. |
| **Цахим хуудас** | *Загвар:*<br>Зохиогчийн овог, нэр: Цахим хуудасны гарчиг: Вэбсайт, Нийтэлсэн он, Цахим холбоос (сүүлд хандсан огноо) . |
| | *Жишээ:*<br>Erichsen, Cornelia/Dunya Hayali/Raul Mutig: Inklusion im Internet: So werden Social-Media-Inhalte barrierefrei, in: t3n, 2020, https://t3n.de/magazin/inklusion-im-internet-so-werden-249553/ (abgerufen am 05.11.2020). |
| **Сонины мэдээ** | *Загвар:*<br>Зохиогчийн овог, нэр: Нийтлэлийн гарчиг: Сонин, Огноо, Цахим холбоос (сүүлд хандсан огноо) |
| | *Жишээ:*<br>Rodemann, Julian: Chemie-Nobelpreis geht an zwei Genforscherinnen, in: Süddeutsche Zeitung, 07.10.2020, https://www.sueddeutsche.de/wissen/nobelpreis-2020-chemie-1.5057356 (abgerufen am 05.11.2020). |
| **Хуулийн заалт** | *Жишээ*<br>§ 81 Absatz 1 Satz 2 BGB<br>§ 81 Abs. 1 S. 2 BGB |
| **Шүүхийн шийдвэр** | *Загвар:*<br>Шийдвэр гаргасан шүүхийн нэр, Огноо, шийдвэрийн дугаар |
| | *Жишээ:*<br>OLG Hamburg, 4. November 2013, Az. XI Z 243/13 |

[3] Герман хэл дээр эшлэл хийх аргачлалыг дараах материалыг ашиглан хураангуйлсан болно. Gesetze zitieren - Anleitung für deine Abschlussarbeit (scribbr.de)

## 4. ФРАНЦ ХЭЛ ДЭЭРХ ЭШЛЭЛ[4]

| | |
|---|---|
| **Ном** | *Загвар:*<br>Зохиогчийн овог, нэр. *Номын нэр.* Хэвлэгдсэн газар (хот): Хэвлэлийн газар, хэвлэгдсэн он. |
| | *Жишээ:*<br>Carley, Michael J. *L'Alliance de la Dernière Chance : Une Réinterprétation des Origines de la Seconde Guerre Mondiale.* Montréal : Les Presses de l'Université de Montréal, 2001. |
| **Өгүүлэл** | *Загвар:*<br>Овог, нэр. "Өгүүллийн гарчиг. » *Сэтгүүлийн нэр* Дугаар (Хэвлэгдсэн он): хуудас. Мэдээллийн сан (хэрэв байгаа бол). |
| | *Жишээ:*<br>Vibert, Sarah. « Anorexie Mentale et Fonctionnements Limite. Traitement Diversifié de la Perte et du Conflit Oedipien à l'Adolescence. » *Évolution Psychiatrique* 76.1 (2011) : 55-74. *Scholar's Portal*. Web. Le |
| **Хуулийн заалт** | *Загвар:*<br>Дугаар Батлагдсан огноо Хуулийн нэр (Journal Officiel-д бүртгэгдсэн огноо). |
| | *Жишээ:*<br>Loi n°67-1176 du 28 décembre 1967 relative à la régulation des naissances (J.O. 29 décembre 1967). |
| **Шүүхийн шийдвэр** | *Загвар:*<br>Шүүхийн товчилсон нэр (жишээ нь дээд шүүх /Conseil d'Etat/ бол CE), өдөр сар он, хэргийн нэр, дугаар. |
| | *Жишээ:*<br>CE, 27 décembre 1947, Rec. CE, p.498. |

## 5. ЯПОН ХЭЛ ДЭЭРХ ЭШЛЭЛ[5]

| | |
|---|---|
| **Ном** | *Загвар:*<br>Зохиогчийн нэр『номын нэр（хэд дэх хэвлэл）』(хэвлэлийн газар・он) хуудасны дугаар。 |
| | *Жишээ:*<br>*Эхний удаа эшлэх тохиолдолд:*<br>宇賀克也『行政法概説Ⅰ（第 7 版）』（有斐閣・2020 年）503 頁。<br>*Хоёр дахь удаа эшлэх тохиолдолд:*<br>玉蟲・前掲注（37）222 頁。<br>*Олон зохиогчтой тохиолдолд:*<br>H・ミッタイス＝H・リーベリッヒ（世良晃志郎訳）『ドイツ法制史概説（改訂版）』391 頁（創文社・1971 年）。 |
| **Өгүүлэл** | *Загвар:* |

[4] Франц хэл дээр эшлэл хийх аргачлалыг Канад Улсын Лорентиан их сургуулийн цахим хуудаснаас танилцсан болно. Дэлгэрүүлэн үзэх холбоос: https://biblio.laurentian.ca/research/fr/guides/citer-ses-sources,

[5] Япон хэл дээр эшлэл хийх аргачлалыг Токиогийн их сургуулийн Хууль зүйн сургуулиас гаргасан эшлэл хийх аргачлалыг "東京大学法科大学院ローレビュー第 12 期編集委員会「東京大学法科大学院ローレビューにおける文献の引用方法」（2017 年 ）"-ийг ашигласан болно.

| | |
|---|---|
| | Зохиогчийн нэр「өгүүллийн нэр」сэтгүүлийн нэр дугаар （он） хуудасны дугаар。 |
| | *Жишээ:*<br>玉蟲由樹「人間の尊厳の客観法的保護」福岡大学法学論集 51 巻 4 号（2008 年）169 頁。 |
| **Илтгэл болон хуралдааны үеэр хэлсэн үг** | *Загвар:*<br>зохиогчийн нэр「сэдвийн нэр」сэтгүүлийн нэр дугаар〔үг хэлсэн хүний нэр〕（он）。 |
| | *Жишээ:*<br>小川秀樹ほか「新破産法と否認の実務（中）」金法 1730 号 20 頁〔田原睦夫発言〕（2005 年）。 |
| **Хуулийн заалт** | *Загвар:*<br>хуулийн нэр заалт (батлагдсан он)「.......」。 |
| | *Жишээ:*<br>行政手続法(１９９４年)４条「.......」。 |
| **Шүүхийн шийдвэр** | *Загвар:*<br>шүүхийн нэр, шийдвэрийн он сар өдөр, нийтлэгдсэн шүүхийн сэтгүүл дугаар, хуудас |
| | *Жишээ:*<br>大阪地裁平成 20 年 1 月 31 日判決判例タイムズ 1268 号 152 頁。 |
| **Бусад** | *Загвар:*<br>эрхлэн гаргасан байгууллага「нэр」（он сар өдөр） （цахим холбоос, сүүлд үзсэн он сар өдөр）。 |
| | *Жишээ:*<br>金融庁「空売り規制・自己株式取得に係る時限措置の延長に関する内閣府令・告示の公布 について」2011 年 10 月 31 日（http://www.fsa.go.jp/news/23/syouken/20111031-2.html, 2011 年 12 月 1 日最終閲覧）。 |

## 6. ХЯТАД ХЭЛ ДЭЭРХ ЭШЛЭЛ[6]

| | |
|---|---|
| **Ном** | *Загвар:*<br>Зохиогч, Бүтээлийн нэр [таних тэмдэг]. Хэвлэсэн газар:хэвлэсэн байгууллага, хэвлэсэн огноо: хуудасны дугаар. |
| | *Жишээ:*<br>刘国钧,陈绍业.图书目录[M].北京:高等教育出版社,1957:15-18. |
| **Өгүүлэл** | *Загвар:*<br>Зохиогч. Бүтээлийн нэр[J]. Сэтгүүлийн нэр,он,дугаар: хуудасны дугаар. |

[6] Хятад хэл дээр эшлэл хийх аргачлалыг БНХАУ-ын Бээжингийн их сургуулийн магистрын диссертаци бичих удирдамжийг ашиглаж боловсруулсан болно. Дэлгэрэнгүй үзэх холбоос: https://mba.phbs.pku.edu.cn/2015/guide_1030/612, https://baike.baidu.com/item/%E5%8F%82%E8%80%83%E6%96%87%E7%8C%AE%E6%A0%87%E5%87%86%E6%A0%BC%E5%BC%8F/15571284
Хамгийн чухал нь тус улсын GB3569-83 дугаар “эх сурвалжийн төрлийг орлох тэмдэг”-ийн тогтоолыг барих ёстой. Тухайлбал, [M]- ном, [J]- сэтгүүл, [N]-сонин, мэдээ, [D]-дипломын ажил, [R]- судалгааны тайлан гэх мэт төлөөлөх тэмдгийг анхаарах ёстой.

| | |
|---|---|
| | *Жишээ:*<br>何龄修.读南明史[J].中国史研究,1998(3):167-173. |
| **Хуулийн заалт** | *Жишээ:*<br>《刑法》第 XX 条 XX 项 XX 款规定 |
| **Цахим эх сурвалж** | *Загвар:*<br>Зохиогч. Цахим бүтээлийн нэр [Цахим таних тэмдэгт].Цахим сангийн нэр, гаргасан огноо/хэрэглэсэн огноо. |
| | *Жишээ:*<br>王明亮.关于中国学术期刊标准化数据库系统工程的进展[EB/OL].1998-08-16/1998-10-01. |
| **Сонины мэдээ** | *Загвар:*<br>Зохиогч.Бүтээлийн нэр[N].Сонин/мэдээний нэр,он-сар-өдөр(дугаар). |
| | *Жишээ:*<br>谢希德.创造学习的新思路[N].人民日报,1998-12-25(10). |

## 7. СОЛОНГОС ХЭЛ ДЭЭРХ ЭШЛЭЛ[7]

| | |
|---|---|
| **Ном** | *Загвар:*<br>Зохиогчийн нэр, Гарчиг (Засвар орсон бол хэвлэлийн дугаар), Хэвлэн нийтлэгч (Хэвлэгдсэн он), Хуудасны дугаар. |
| | *Жишээ:*<br>정웅석·백승민, 형사소송법(전정제 5 판), 대명출판사 (2012), 77. |
| **Өгүүлэл** | *Загвар:*<br>Зохиогчийн нэр, “Гарчиг”, Сэтгүүлийн нэр Сэтгүүлийн дугаар (Хэвлэгдсэн он сар), Хуудасны дугаар. |
| | *Жишээ:*<br>이창희, “세법상 속인주의와 속지주의의 대립”, 서울대학교 법학 제 50 권 제 1 호(2009. 3.), 237. |
| **Хуулийн заалт** | *Загвар:*<br>Хуулийн нэр (бүтэн эсвэл товчилсон нэр) Зүйл Хэсэг. |
| | *Жишээ:*<br>장사 등에 관한 법률 시행령 제 18 조 제 1 항. |
| **Шүүхийн шийдвэр** | *Загвар:*<br>Шүүхийн нэр Шийдвэрийн огноо Шийдвэр Шийдвэрийн дугаар. |
| | *Жишээ:*<br>대법원 1992. 5. 26. 선고 92 다 84 판결. |
| **Дипломын ажил** | *Загвар:*<br>Зохиогчийн нэр, “Гарчиг”, Бакалавр/Магистр/Докторын ажил, Их сургуулийн нэр (он), Хуудасны дугаар. |
| | *Жишээ:*<br>김형근, “언론의 인격권 침해에 대한 사법상 구제”, 석사학위 논문, 서울대학교 (2008), 15. |

[7] Солонгос хэл дээр эшлэл хийх аргачлалыг БНСУ-ын Дээд шүүхийн “Шүүхийн бодлого судалгааны хүрээлэн”-гээс гаргасан 2017 онд гаргасан “Хууль зүйн бүтээлд эшлэл авах тухай жишиг төсөл” -өөс эшилсэн болно. Дэлгэрэнгүй үзэх холбоос: https://jpri.scourt.go.kr/fileDownLoad.do?seq=746